



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 03 сарын 15 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Г

Г

Ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийн Засаг даргын 2012 оны 364 дүгээр захирамжийг үндэслэн
ТУШААХ нь:

1. Нийслэлийн дүүргүүдэд шинээр баригдах усан бассейнуудад ТТНА-13/01 дугаар гэрээний дагуу “Сүвэн–Уул” ХХК-иас нийлүүлэх эмнэлгийн тоног төхөөрөмж, БТТ-12/02 дугаар гэрээний дагуу “Хустайн Хишиг” ХХК-иас нийлүүлэх тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга	А.Болдмаа	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн
Гишүүн	Ж.Цэдэнсодном	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга	Г.Бямбасайхан	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн

2. “Сүвэн–Уул” ХХК, “Хустайн Хишиг” ХХК-даас нийлүүлэх техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилгыг хүлээн авч Баянзүрх, Баянгол, Багануур, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдийн усан бассейнуудад 2013 оны 03 дугаар сарын 13-20-ны өдрүүдэд хүлээлгэн өгөх ажлыг Нарийн бичгийн дарга Г.Бямбасайханд даалгасугай.

3. Дээрх компаниудаас нийлүүлсэн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, акт үйлдэн баримтжуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэстэй тухайн тендерийн баримт бичгийн тооцоог хийж дуусгах ажлыг нягтлан бодогч Ж.Цэдэнсодномд даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД

